



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 039-01/01-ГА.

Сүхбаатар

Г

Г

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсвийг урьдчилан хийгээгүй 764,2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тусгаж, батлуулсан,
- 12 сум нь эрх шилжсэн 234,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй,
- Орхонтуул, Цагааннуур суманд эрх шилжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримт материалын бурдэл дутуу байхад 48,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 487,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл худалдан авалтын гүйцэтгэлийг тоног төхөөрөмжийн хяналтын хүснэгтээр баталгаажуулаагүй,
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу 32,3 сая төгрөгийн алданги тооцоогүй,
- 25,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Цемент шохой компанийн ХХОАТ-ын өрөнд цемент авч борлуулсан хувийн компаниар дамжуулан гүйцэтгүүлснийг нотлох баримт байхгүй, гүйцэтгэлд хяналт тавьж, баримт, материал бүрдүүлээгүй,
- 20,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Шаамар суманд зөөврийн тайз, хөгжим худалдан авах ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар хэрэгжүүлсэн зэрэг нийт 1,611.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд

заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" ТБОНӨХБАУХА тухай хуулийн 33.2 дахь "Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ: 33.2.1. Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа З болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4.5 дахь "...дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ: 4.5.7. Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан баталгаажсан, барилгын ажлын гүйцэтгэл, 4.5.9. ТЭЗҮ, зураг төсөв, техник хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээ" гэсэн заалтууд болон мөн журмын Хавсралт №3, ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөл дэх "Гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0,05 хувь байна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.7-д "Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээг тусгаж байх.
2. Сумдад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулулж, хэрэгжилтэд нь хяналт тавих.
3. Гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож байх.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан тоног төхөөрөмж, машин техникийн гүйцэтгэлийг хяналтын хүснэгтээр баталгаажуулж байх.
5. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Θ.Сувдаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТИН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮПЭХ АУДИТОР
Монг
Ч.ЭНХТУЯА
АХЛАХ АУДИТОР
С.Баасан
С.БААСАНСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ш.ОРГИЛ
ЗДТГ-ЫН ДАРГА
Θ.СУВДАА

Акт, албан шаардлагаын бүртгэл, хяналтын хуудас

Акт /албан шаардлага/ тогтоох үеийн бүртгэл, хяналт

1. Үндсэн мэдээлэл

Аудитын нэр	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд санхүүжүүлсэн төсөл, агаа хэмжээний хэрэгжилт, үр дүн	Аудитын код	СЭАГ-2018/01-ГА		
Акт /албан шаардлага/ ын дугаар	СЭА-01/01-ГА	Тогтоосон огноо	2018.06.25	Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,611,100,000 00

Акт /албан шаардлага/ тогтоосон үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсвийг урьдчилан хийгээгүй төсөл, агаа хэмжээг тусгаж, батуулсан, 12 сум нь эрх шилжсэн төсөл, агаа хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй. Орхонтуул. Цагааннур суманд эрх шилжүүлсэн 3 төсөл, агаа хэмжээний гүйцэтгэлийн баримт материалын бүрдэл дутуу байхад 48.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, нийт 487.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл худалдан авалтын гүйцэтгэлийг тоног төхөөрөмжийн хяналтын хүснэгтээр баталгаажуулаагүй, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, агаа хэмжээг ашиглалтад хулээлгэн өгөх гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу 32.3 сая төгрөгийн алданги тооцоогүй. 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Шаамар суманд зөвхийн тайз, хөгжим худалдан авах ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ.
	Нэр	Төсвийн тухай хууль
	Заалт	29.4 дахь заалт
	Нэр	ТБОНӨХБАЙХА тухай хууль
	Заалт	33.2 дахь заалт
	Нэр	Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"
	Заалт	4.5 дахь заалт
	Нэр	Ажил гүйцэтгэх гэрээ
	Заалт	Тусгай нөхцөл
	Акт /албан шаардлага/ тогтоох эрх зүйн үндэслэл	Төрийн аудитын тухай хууль, МҮЕА-ын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"
	Заалт	Хуулийн 15.1.12, журмын 3.1.7

Актын төлбөр барагдуулах дүн	Төлбөр хийх данс		Актын дүн /төгрөгөөр/ Төлбөр барагдуулах огноо
	Улсын төсвийн дансанд		
	Орон нутгийн төсвийн дансанд		
	Тухайн байгууллагын дансанд		
	Бусад		

2. Нотлох баримтын мэдээлэл

Нотлох баримтын бүрдэл			
Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, агаа хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт-тийн баримт, материалын		2017.01.01- 2017.12.31	
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, агаа хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой баримт, материалын		2017.01.01- 2017.12.31	

3. Акт /албан шаардлага/ тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан болон хариуцагчийн мэдээлэл

Акт /албан шаардлага/ тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан болон хариуцагчийн мэдээлэл			Хариуцагчийн мэдээлэл			
Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Танилцах зөвшөөрөн гарын үсэг
С.Баасансүрэн	Ахлах аудитор	<i>С.Баасан</i>	Сэлэнгэ аймгийн ТЭЗ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Ш.Оргил Ө.Сувдаа	<i>Ш.Оргил</i> <i>Ө.Сувдаа</i>

4. Акт /албан шаардлага/ тогтоох үеийн хяналт

4.1 Эхний хяналтын бүртгэл

№	Хяналт хийсэн албан тушаалтан	Хянасан огноо	Хяналтаар өгсөн зөвлөмж	Хянасан ажилтны гарын үсэг
1	Аудитын менежер			
2	Тэргүүлэх аудитор	<u>VI/22</u>	<i>Аудит, эхийн түүрүү цэвэршил (хамаагүй) Мэдээлэл</i>	<i>Мэдээлэл</i>
3	Хуулийн ажилтан			

4.2 Хяналтын баталгаажуулалт

№	Баталгаажуулсан	Зөвшөөрсөн огноо	Баталгаажуулсан гарын үсэг ба хурлын шийдвэр
1	Тэргүүлэх аудитор	<u>VI/22</u>	<i>Мэдээлэл</i>
2	Удирдлагын хурлын шийдвэр	<u>VI/22</u>	<i>Баталгаажуулсан гарын үсэг ба хурлын шийдвэр</i>

4317143958
МОА6865-3055436